



СТЕП ГОЛД ХХК

КОМПАНИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН БОДЛОГО

1. Ерөнхий

Компанийн засаглал ба Нэр дэвшүүлэх хорооны саналаар Степ Голд ХХК (“Степ” гэх) – ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс Степ Компанийн Ил тод байдлын тухай өөрийн бодлогыг Канадын Үндэсний гэрээ 51-102 – *Байнгын нийтийн хүртээл байдлыг хангах үүрэг хариуцлага* ба Үндэсний Бодлого 51-201 – *Ил тод байдлын стандарт* –ын дагуу томъёолох шаардлагатай юм хэмээн тогтоолоо. Энд хэрэглэгдсэнчлэн, “Степ” болон “Компани” гэдэгт Степ болон түүний салбар компаниудыг ойлгоно.

2. Бодлогын Зорилго

Энэхүү Компанийн Ил тод байдлын бодлогын (“**Бодлого**” гэх) зорилго нь:

- (a) Компанийн бизнес ба үйл ажиллагааны талаар олон нийтэд хүргэж буй бүх мэдээлэл харилцааг зөвхөн мэдээллийн шинжтэй, сүүлийн үеийн, үнэн зөв, бодитой, хүчин төгөлдөр хууль эрх зүйн шаардлагуудад нийцүүлэн, тэдгээрийн дагуу нийтийн хүртээл болгох зорилгоор Канадын Үнэт цаасны тухай хууль тогтоомж ба Торонтогийн Хөрөнгийн Бирж ("TSX") - ийн дүрэм журмаар тогтоосон байнгын нийтийн хүртээл байдлыг хангах үүргийг даган мөрдөх Компанийн хүлээсэн үүргийг бататгах;
- (b) Компанийн одоо мөрдөж буй Ил тод байдлын тухай бодлогууд, удирдамж, журмуудыг бичгээр баталгаажуулах;
- (c) Энэхүү бодлого хамаарах бүх этгээдүүдэд мэдээллийн нууцлалыг хадгалах үүргийг нь сайтар ойлгуулах;
- (d) Хувьцаа эзэмшигчидтэй харилцах үр дүнтэй харилцааг дэмжих, ерөнхий хурлууд дээр тэдний оролцоог урамшуулан дэмжих; ба
- (e) Дээрх зорилтуудыг хангахын тулд Ил тод байдлын хороог үүсгэн байгуулах.

3. Бодлогын хэрэглээ

Компанийн нууцлалын мэдээлэлд нэвтрэх боломжтой Компанийн бүх захирлууд, албан хаагчид, ажилчид, зөвлөхүүд болон гүйцэтгэгч нар (“**Төлөөлөгчид**” гэх) болон Степийг төлөөлөх эрхтэй этгээдүүд уг Бодлогыг заавал даган мөрдөнө. Энэхүү Бодлого нь хөрөнгийн бирж, үнэт цаасны тохирүүлгуудтай холбоотой баримтаар үйлдсэн бүхий л тодруулгууд, Компанийн жилийн болон улирлын тайлангууд, хэвлэлийн мэдэгдэл, хувьцаа эзэмшигчдэд хандсан захидал бичгүүд, ахлах шатны удирдлагуудын хийсэн танилцуулга ба Компанийн веб хуудас, бусад цахилгаан харилцаа холбооны хэрэгсэлд агуулагдсан мэдээллүүд гэх мэт бүхий л санхүүгийн болон санхүүгийн бус тодруулгуудыг хамарна. Энэ нь мөн хурлууд дээр хэлсэн бүхий л мэдээлэл, тайлан, шинжээчид болон хөрөнгө оруулагчидтай хийсэн утсаар хийсэн ярилцлага, хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан ярилцлага, танилцуулгууд, хэлсэн үгс, хэвлэлийн хурал, бага хурлын тэмдэглэл, вебсайтуудад өгсөн ярилцлага зэргийг багтаана.

4. Бодлогыг танилцуулах нь

Энэхүү Бодлогын хуулбарыг биечлэн өгөх, эсвэл Компанийн веб хуудас www.steppegold.com дээр байрлуулах замаар бүх Төлөөлөгчдөд хүргэнэ. Томоохон өөрчлөлтүүдийг хийсэн тохиолдолд бүх Төлөөлөгчдөд мэдэгдэнэ. Шинэ Төлөөлөгчдөд энэ Бодлогын хуулбарыг өгнө.

5. Захиргааны хариуцлага

5.1 Ерөнхий

Гүйцэтгэх Захирал болон Гүйцэтгэх дэд-ерөнхийлөгчийг бүрэлдэхүүндээ багтаасан Компанийн Ил тод байдлын хороо нь Компанийн Ил тод байдлын бодлогын хэрэгжилтэд хяналт тавих, дотоод мэдээллийн үнэлгээнд жишиг тогтоох, дотоод мэдээллийг хэзээ олон нийтэд нийтийн хүртээл болгохыг тодорхойлох, энэ бодлогыг даган мөрдүүлэх асуудлыг хариуцдаг.

Степд бүхий л эрх зүйн болон зохицуулах тодруулгуудын шаардлагуудыг даган мөрдүүлэх асуудлыг голлон хариуцдаг этгээд нь Гүйцэтгэх захирал юм. Эдгээр шаардлагууд гэдэгт:

- (a) Компанийн компанийн Ил тод байдлын хэрэгжилт болон энэхүү Бодлогыг даган мөрдөж буйд хяналт тавих;
- (b) Дээд шатны удирдлагын бусад гишүүдээс зөвлөгөө, мэдээлэл авах замаар энэхүү Бодлогод заасан үйл явц, журмын дагуу дотоод мэдээллийг нээлттэй болгох үйл ажиллагааг эхлүүлэх; ба
- (c) Зохицуулагч эрх бүхий байгууллагаас хэдийд ч гаргаж болох аливаа асуудлыг шийдвэрлэх.

Компанийн Гүйцэтгэх захирал, Гүйцэтгэх дэд-ерөнхийлөгч болон Гүйцэтгэх захирлын зүгээс цаашид томилж болох тэдгээр хувь хүмүүс нь (“төлөөлөгчид” гэх), хөрөнгө оруулалтын шинжээчид, хувьцаа эзэмшигчид, ирээдүйн хөрөнгө оруулагчид болон хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй харилцах, танилцуулгуудыг бэлтгэх, хяналт тавих, шинжээчид болон санхүүгийн салбарын бусад гишүүдтэй хурал зохион байгуулах, энэхүү Бодлоготой холбогдох аливаа электрон холбоогоор дамжин гүйцэтгэгдэх үйл ажиллагаануудад хяналт тавих үүрэг хүлээсэн этгээдүүд юм. Энэхүү үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэхдээ, Төлөөлөгчид нийтийн хүртээл болоогүй бүхий л дотоод мэдээллийг зөвхөн сонгогдсон бүлэгт л нийтийн хүртээл болгох тал дээр онцгой анхаарна. Хэрэв, ямар нэгэн шалтгааны улмаас, нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээллийг шинжээчид, хөрөнгө оруулагчид, хэвлэл мэдээллийнхэн болон бусад этгээдүүдэд нийтийн хүртээл болгосон бол, Гүйцэтгэх захирал болон Гүйцэтгэх дэд-ерөнхийлөгч нарт нэн даруй мэдэгдэнэ.

5.2 Ил тод байдлын хороо

Степ нь Ил тод байдлын хороог (“Ил тод байдлын хороо” гэх) байгуулах бөгөөд уг хороо нь компанийн дотоод мэдээлэл мөн эсэхийг тогтоох, дотоод мэдээллийг хүчин төгөлдөр хэрэгжиж буй үнэт цаасны тухай хууль болон хөрөнгийн биржийн дүрэм журмын дагуу цаг хугацаанд нь нийтийн хүртээл болгох, энэ бодлогыг даган мөрдөж байгаа болон Компанийн нийтэд ил тод болгож буй мэдээ мэдээлэлд хяналт тавих ажлыг хариуцан гүйцэтгэдэг.

Ил тод байдлын хорооны гишүүд:

- (a) Гүйцэтгэх захирал ;
- (b) Гүйцэтгэх дэд-ерөнхийлөгч;
- (c) Санхүүгийн захирал; болон
- (d) Гүйцэтгэх захирлын зүгээс хэдийд ч томилж болох хуулийн этгээд.

Ил тод байдлын хорооны гишүүн бүр итгэмжлэгдсэн төлөөлөгч томилж болно. Ил тод байдлын хорооны шийдвэрүүдийг хорооны гишүүдийн, эсвэл тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн олонхийн саналаар гаргадаг. Гэхдээ, Ил тод байдлын хорооны дор хаяж хоёр гишүүн, эсвэл хоёр итгэмжлэгдсэн төлөөлөгч ямар нэгэн асуудлаар шийдвэр гаргах шаардлагатай хугацаанд багтаж тухайн асуудлаар зөвлөлдөх үед зайлшгүй шалтгааны улмаас ирэх боломжгүй байвал, Ил тод байдлын хорооны бусад гишүүд эсвэл тэдний итгэмжлэгдсэн төлөөлөгчид шаардлагатай асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргана.

Компанийн ерөнхий нарийн бичгийн дарга эсвэл Гүйцэтгэх захирлын томилсон хуулийн этгээд Ил тод байдлын хорооны хурлыг зохон байгуулж, хэлэлцэх асуудлыг бэлдэж, холбогдох төсөл, бичиг баримтыг цуглуулан боловсруулж, хурлын тэмдэглэл болон Ил тод байдлын хорооны шийдвэрийг бүртгэж тэмдэглэнэ.

5.3 *Компанийн хөгжлийн талаар Ил тод байдлын хороо бүрэн мэдээлэлтэй байх ёстой*

Компанийн бүх ажилчид, өөрсдөө шууд эсвэл өөрсдийн шууд харъяалагдах удирдах албан тушаалтнаараа дамжуулан, компанийн санхүү болон үйл ажиллагаанд нөлөөлөх ноцтой асуудлуудын талаарх мэдээллийг хангалттай өгөх ёстой. Ингэснээр Ил тод байдлын хорооны гишүүд нийтийн хүртээл байдлыг хангах үүргээ биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх аливаа нөхцөл байдлын талаар хэлэлцэж, үнэлгээ өгөх боломжтой болох юм.

6. Ерөнхий удирдамж

6.1 *дотоод мэдээллийг нийтийн хүртээл болгох зарчмууд*

Канадын Үнэт цаасны тухай хууль тогтоомж ба Торонтогийн Хөрөнгийн Бирж ("TSX") - ийн дүрэм журмаар тогтоосон нийтийн хүртээл ил тод байдлыг хангах үүргээ биелүүлэх болон дотоод мэдээллийг түгээхдээ, Степ дараах зарчмуудыг мөрдөнө:

- (a) дотоод мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж нийтийн хүртээл болгоно. Нийтийн хүртээл болгохдоо даган мөрдөх бүх журмыг мөрдөнө;
- (b) Компанийн бизнес, ажил хэрэгт гарсан чухал өөрчлөлтүүдийг Канадын үнэт цаасны зохицуулагч байгуулагад аль болох хурдан хугацаанд, эсвэл чухал өөрчлөлт бий болсон өдрөөс хойш арван /10/ хоногийн дотор чухал өөрчлөлтийн тайланд оруулна. Гүйцэтгэх захирлын зүгээс нууцлалтай хэвээр үлдэх ёстой гэж үзсэн чухал өөрчлөлт гарсан нөхцөлд, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ("Зөвлөл" гэх) зөвшөөрлөөр, нууцлалтай чухал өөрчлөлтийн тайланг Канадын үнэт цаасны зохицуулагч байгууллагад бүртгүүлэх ба, Гүйцэтгэх захирал, Зөвлөл нар мэдээллийг нууцлалтай байлгах талаар өөрсдийн шийдвэрийг арван /10/ хоног тутамд эргэн хянана;

- (c) Нийтийн хүртээл болгоход тохиромжтой ба нийтийн хүртээл болгоход тохиромжгүй дотоод мэдээлэлд ямар ч ялгаа байхгүй. Аль ч төрлийн мэдээллийг энэхүү Бодлогын дагуу зохих хугацаанд, үнэн зөв, бүрэн бүтнээр нь нийтийн хүртээл болгоно;
- (d) Аливаа мэдээллийг нийтийн хүртээл болгох ажиллагаа бүрэн гүйцэд явагдах ёстой бөгөөд аль нэг зүйлийг орхигдуулсан нөхцөлд нийтийн хүртээл болгох ажиллагааг алдаатай гүйцэтгэсэн гэж үзнэ;
- (e) Аль нэг шинжээч, тодорхой хөрөнгө оруулагч эсвэл өөр этгээдийн хувьд нийтийн хүртээл болгоно, нийтийн хүртээл болгохгүй гэсэн сонгох зүйл байх ёсгүй;
- (f) Нийтийн хүртээл болгох, нийтэд мэдээлэх үйл явцыг Хамтын ажиллагааны бодлого 51-102СР - байнгын нийтийн хүртээл байдлыг хангах үүргийн дагуу үнэн зөв, бүрэн бүтэн энгийн ойлгомжтой байдлаар гүйцэтгэх ёстой; ба
- (g) Дотоод мэдээлэлд тооцогдох мэдээллийг олж авсан, энэхүү Бодлого хамаарах хэн бүхэн уг мэдээллийг 5.2 дахь Хэсэгт тогтоосон Ил тод байдлын хорооны гишүүдийн аль нэгэнд нэн даруйхан мэдээлнэ.

6.2 дотоод мэдээлэл

Аль нэг мэдээлэл нь дотоод мэдээлэл мөн эсэхийг тогтоохдоо, дараах хүчин зүйлсийг авч үзнэ. Үүнд:

- (a) Мэдээллийн мөн чанар, Компанийн үнэт цаасны хөрвөх чадвар болон зах зээлийн давамгайлах нөхцөл бодит байдалд уг мэдээлэл хэрхэн нөлөөлөх талаар;
- (b) аливаа мэдээллийн дотоод мэдээлэлд хамаарах эсэх тухай тодорхойлолт нь ихэвчлэн түршлага дээр суурилсан бизнесийн зөв шийдвэрийг хэрэгжүүлэх үйл явцыг хамардаг; ба
- (c) хэрэв мэдээлэл дотоод мэдээлэлд хамаарах эсэх нь эргэлзээтэй байвал, Степ уг мэдээлэлд маш болгоомжтой хандах ёстой бөгөөд мэдээллийг нийтийн хүртээл болгох ёстой.

Дотоод мэдээллийн бүх ангиллыг тодорхойлох боломжгүй. Гэхдээ, тухайн мэдээлэл Компанийн үнэт цаас, хувьцааг худалдан авах, эсвэл зарахтай холбоотой аливаа хөрөнгө оруулалтын шийдвэрийг гаргахад нь аль нэг хөрөнгө оруулагчийн хувьд чухалд тооцогдох магадлалтай байвал уг мэдээллийг дотоод мэдээлэл гэж үзнэ. Дотоод мэдээлэл болон нөхцөл байдлаас хамаарч дотоод мэдээллийн ангилалд багтаж болох мэдээллийн жишээнүүдийн бүрэн бус жагсаалтыг үзэх бол Компанийн Үнэт цаасны арилжааны бодлогын Хавсралт Б “Дотоод мэдээллийн ангилалд багтаж болох мэдээллийн жишээ” -ийг үзнэ үү.

6.3 Хэвлэлийн мэдэгдэл гаргах нь

Ил тод байдлын хороо нь аливаа дотоод мэдээллийг нийтийн хүртээл болгох, олон нийтэд мэдээлэх эсэхийг тодорхойлно. Тиймээс:

- (a) Гүйцэтгэх захирал ба/эсвэл Гүйцэтгэх дэд-ерөнхийлөгч хэвлэлийн мэдэгдэлийн төслийг бэлдэнэ. Уг төслийг Ил тод байдлын хорооны гишүүд хэлэлцэнэ. Мөн шаардлагатай бол бусад холбогдох ажилчдад нийтэд танилцуулахаар төлөвлөж буй хэвлэлийн мэдэгдэлийн агуулгыг танилцуулж, тэднээр хянуулна;
- (b) тодорхой хяналтаар орж бэлэн болсон хэвлэлийн мэдэгдэлийг сүүлийн хяналт хийлгэж, батлуулах, олон нийтэд мэдээлэх зөвшөөрөл авах зорилгоор Ил тод байдлын хороонд, хэрэв хэвлэлийн мэдэгдэлд санхүүгийн мэдээлэл агуулагдсан бол Аудитын хороо болон Төлөөлөн Удирдах Зөвлөлд тус тус хүргүүлнэ;
- (c) батлагдсан нөхцөлд, хэрэв боломжтой бол, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр цацахаас өмнө ийм хэвлэлийн мэдэгдэлийг Канадын Хөрөнгө Оруулалтын Салбарын Зохицуулагч Байгууллага (“IIROC”) руу илгээнэ;
- (d) хэвлэлийн мэдэгдэлийг нийтийн хүртээл болгосны дараа, Степ түүнийг Канадын үнэт цаасны хадгаламжийн төвийн үйлчилгээ болох Цахим баримт бичгийн дүн шинжилгээ, хайлтын систем (SEDAR)-д архивлаж, хэвлэлийн мэдэгдэлийн агуулгыг Компанийн веб хуудсан дээр нийтлэнэ;
- (f) хэвлэлийн мэдэгдэлд санхүүгийн мэдээлэл агуулагдсан бол, хэвлэлийн мэдэгдэлийг санхүүгийн тайлан болон бусад холбогдох бичиг баримтын хамт Канадын үнэт цаасны хадгаламжийн төвийн үйлчилгээ болох Цахим баримт бичгийн дүн шинжилгээ, хайлтын систем (SEDAR)-д архивлана;
- (g) хэрэв телефон хурал хийхээр төлөвлөсөн бол, дотоод мэдээлэл болон бусад гол асуудлын талаар хэлэлцэх аливаа телефон хурлын огноо ба цагийн талаар хэвлэлийн мэдэгдэл гарган урьдчилж мэдэгдэнэ;
- (h) хөрөнгө оруулагч болон бусад хүмүүст утсаар эсвэл интернет вэбсайтаар сонсох боломжийг олгон телефон хурлыг нээлттэй байдлаар зохион байгуулна; мөн
- (i) телефон хурлын дараа хурлын бичлэг болон тэмдэглэлийг тодорхой хугацаанд үзэж, харах боломжтой байлгана.

6.4 *Хэвлэлийн төлөөлөгчидийн томилгоо*

Хэвлэлийн төлөөлөгчдөөс бусад ажилчид нь хөрөнгө оруулалтын баг, хэвлэл мэдээллийнхэн, зохицуулагч байгууллага болон бусад этгээдээс асууж лавласан зүйлд ямар ч нөхцөлд хариулт өгөх ёсгүй бөгөөд ийм төрлийн асуудлыг зөвхөн хэвлэлийн төлөөлөгч хариуцна. Компанийн аль нэг салбарын хэвлэлийн төлөөлөгчийг Гүйцэтгэх захирал томилно.

Эрх бүхий ч бай, үгүй ч бай буруу ташаа мэдээлэл олон нийтэд хүргэсэн Компанийн аль ч хэвлэлийн төлөөлөгчийг шүүхэд өгч болно. Мөн түүнчлэн, олон нийтэд буруу ташаа мэдэгдэл гаргасан Компанийн захирал, ажилтныг мөн шүүхэд өгч болно.

6.5 *Мэдээллийн нууцлал*

Компанийн бүх Төлөөлөгчид хуулийн дагуу нууцлалын мэдээллийг Степт хамааралгүй хэн нэгэн этгээдэд задруулахгүй байх үүрэгтэй. Мөн түүнчлэн, хуулийн дагуу бүх Төлөөлөгчид дараах зүйлсийг дагах мөрдөх ёстой. Үүнд:

- (a) Компанийн бизнес, ажил хэргийн талаар бусдад дуудахаар газар хэлэлцэн, ярилцаж болохгүй;
- (b) Нууцлалын бичиг баримтыг олон нийтийн газар уншиж, ил дэлгэн харуулж болохгүй;
- (c) Нууцлалын мэдээлэл агуулсан бичиг баримт, хавтсыг аюулгүй газар хадгалж, зөвхөн хязгаарлагдмал тооны этгээдүүд нэвтрэх боломжтой байлгана;
- (d) нууцлалтай нөхцөлд хийгдэж, хүлээн авч, ашиглах нь баталгаатай байгаа нөхцөлд л бичиг баримтыг факсаар, цахилгаан шуудангаар эсвэл бусад электрон хэрэгслээр дамжуулж болно; мөн
- (e) хуралд болсны дараа нууцлалын мэдээлэл агуулсан бичиг баримтыг хурлын өрөө болон ажлын орчноос хураан авч, нууцлалтай бичиг баримтуудын хуулбаруудыг устгах ёстой.

Иймэрхүү нийтийн хүртээл болгоогүй нууцлалын мэдээлэлд нэвтрэх эрхийг зөвхөн тухайн мэдээлэл зайлшгүй хэрэгтэй хүмүүст л олгож, нэвтрэх эрхийг хязгаартай байлгах ёстой бөгөөд нэвтрэх эрх авсан хүмүүст уг нууцлалын мэдээллийг маш өндөр нууцлалын доор ашиглах ёстой талаар зөвлөнө.

Стептэй бизнес ажил хэрэг өрнүүлэх явцдаа нийтийн хүртээл болгоогүй нууцлалын мэдээллийг хүлээн авсан, эсвэл уг мэдээлэлтэй холбогдолтой гадны буюу хөндлөнгийн этгээдүүд нууцлалын гэрээг бичгээр үйлдэж, байгуулах замаар нууцлалыг үл задруулах амлалт өгч, үүрэг хүлээх ёстой.

6.6 Мэдээллийг сонголтоор нийтийн хүртээл болгох

Компанийн бүх Төлөөлөгчид нийтийн хүртээл болгохгүй дотоод мэдээлэл зэрэг нууцлалын мэдээллийг Степт хамааралгүй бусад этгээдэд задруулахгүй байх үүргийг хуулиар хүлээсэн. Олон нийтэд нийтийн хүртээл болгоогүй ийм мэдээллийг хөрөнгө оруулалтын шинжээчид, хөрөнгө оруулалтын байгууллага, бусад зах зээлийн мэргэжилтнүүд болон хэвлэл мэдээллийнхэн гэх мэт аливаа этгээд, сонгосон бүлэгт задруулах үйл явцыг сонголтоор нийтийн хүртээл болгох үйл явц гэж үзнэ. Сонголтоор нийтийн хүртээл болгох үйл явц нь хууль бус бөгөөд хориотой үйлдэл юм.

6.7 Санамсаргүйгээр мэдээллийг сонголтоор нийтийн хүртээл болгох

Мэдээллийг задруулахаас өмнө нийтийн хүртээл болгоогүй дотоод мэдээлэл байсныг нь мэдэлгүйгээр, санамсар болгоомжгүйгээр дотоод мэдээллийг нийтийн хүртээл болгосон бол энэ тохиолдлыг санамсаргүйгээр мэдээллийг нийтийн хүртээл болгосон үйлдэл гэж үзнэ. Хэрэв санамсаргүйгээр мэдээллийг нийтийн хүртээл болгож, задруулсан бол, энэ талаараа Ил тод байдлын хороонд даруйхан мэдэгдэх ёстой. Ил тод байдлын хорооноос дараах шаардлагатай арга хэмжээнүүдийг нэн даруйхан авна. Үүнд:

- (a) санамсаргүйгээр мэдээллийг нийтийн хүртээл болгосон тухайгаа Торонтогийн Хөрөнгийн Биржид даруйхан мэдэгдэж, хэвлэлийн мэдэгдлийг гаргахаас өмнө арилжааг түр зогсоох эсэхээ Торонтогийн Хөрөнгийн Биржтэй хамтарч тогтооно;
- (b) хэвлэлийн мэдэгдэл гаргах замаар дотоод мэдээллийг нийтийн хүртээл болгоно; мөн
- (c) санамсаргүйгээр мэдээллийг задруулсан тэр этгээдэд нь тухайн нийтийн хүртээл болгосон мэдээллийг нийтийн хүртээл болгоогүй байсан тухай мэдэгдэж, тухайг мэдээллийн нууцлалыг хангахыг сануулж, мөн тухайн мэдээллийг олон нийтийн хүртээл болготол уг мэдээлэлтэй холбогдох Компанийн хувьцааг арилжаалахгүй байх талаар мэдэгдэнэ.

7. Зохицуулагч байгууллагуудтай харилцах нь

Хэрэв хөрөнгийн бирж, эсвэл бусад үнэт цаасны зохицуулах байгууллагаас цуу ярианы хариуд олон нийтэд мэдэгдэл гаргахыг шаардвал, Ил тод байдлын хороо мэдэгдэл гаргах талаар арга хэмжээ авч, задруулсан мэдээллийн агуулгыг тодорхойлно. Шийдвэр гаргахдаа, хэрэв үнэт цаасны зохицуулагч байгууллагаас эсвэл өөр хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө өгсөн бол тэдгээр зөвлөгөө, зөвлөмжүүдээс аль зохистойг нь авч үзнэ.

Хэвийн бус арилжааны үйл ажиллагаа, зах зээлд тархсан цуу яриа, эсвэл ижил төстэй асуудалтай холбогдуулан Канадын Хөрөнгө Оруулалтын Салбарын Зохицуулагч Байгууллага (“IIROC”) -аас ирэх асуулт, лавлагаануудыг хүлээн авах үүргийг Гүйцэтгэх Захирал хүлээнэ.

Дотоод мэдээллийн талаар хэвлэлийн мэдэгдэл гаргахаас өмнө хэвлэлийн мэдэгдэл гаргах зөвшөөрөл хүсэх, хэвийн бус арилжааны явцыг ажиглах, арилжааг түр зогсоох шаардлагатай эсэхийг тогтоох зорилгоор Канадын Хөрөнгө Оруулалтын Салбарын Зохицуулагч Байгууллага (“IIROC”) – тай холбоо тогтоох үүрэгтэй.

8. Хөрөнгө оруулагч нартай харьцах нь

8.1 Ерөнхий

Хөрөнгө оруулалтын шинжээчид, үзэт цаас эзэмшигчид, ирээдүйн хөрөнгө оруулагчид, хэвлэл мэдээллийнхэнтэй харилцахдаа, дараах үйлдлийг гаргахаас сэргийлэх ёстой. Үүнд:

- (a) хэвлэлийн мэдэгдэл гаргах замаар нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээллийг зарлах;
- (b) мэдээллийг сонголтоор нийтийн хүртээл болгох;
- (c) Степийг төлөөлөн 2-оос бага тооны хүн ийм харилцаанд оролцох;
- (d) хөрөнгө оруулалтын тайланг олон нийтэд болон ажилчдад тарааж өгөх; болон
- (e) тайлант үеийн ашгийн тооцоо ба санхүүгийн таамаглалуудын талаар тайлбар гаргах.

8.2 *Телефон хурал*

Зарим нь утсаар, зарим нь зөвхөн сонсох горимоор утсаар, эсвэл интернэт веб цацалтаар оролцдог учраас гол асуудлуудын хэлэлцүүлэгт сонирхсон талууд бүгд нэгэн зэрэг оролцох боломжийг хангах үүднээс компанитай холбоотой томоохон асуудлуудын талаар шийдвэр гаргахдаа телефон хурлыг явуулж болно. Хурлыг ингэж явуулах эсэхийг Ил тод байдлын хорооноос цаашид шийдэж болно. Хурлыг явуулахаас өмнө бүхий л холбогдох дотоод мэдээллийг агуулсан хэвлэлийн мэдэгдлийг гаргана. Хурал эхлэхэд, Компанийн Хэвлэлийн төлөөлөгч хурлаар хэлэлцэх гэж буй асуудал, мэдээлэлтэй холбогдуулан зохих сануулгыг өгч, оролцогч бүрт холбогдох эрсдэл, тодорхойгүй байдлын талаарх таамаглал, хэлэлцүүлгийг агуулсан нийтийн хүртээл болсон бичиг баримтуудыг өгнө.

Хурал хэдний өдөр, хэдэн цагт, хэрхэн явагдах болон вебээр цацах эсэх талаар хэвлэлийн мэдэгдлийг гарган, телефон хурал болон веб цацалтын талаарх мэдэгдлийг Сонирхогч талуудад Степ урьдчилан өгнө. Мөн түүнчлэн, Степ хуралд оролцох шинжээчид, хөрөнгө оруулагч байгууллагууд, хэвлэл мэдээллийнхэн болон бусад сонирхогч талуудад урилга илгээнэ. Оролцогчдод өгсөн аливаа дотоод-бус нэмэлт мэдээллийг мөн бусдад харуулах үүднээс Компанийн веб хуудас дээр байрлуулна. Телефон хурал болон веб цацалтын бичлэг, архивласан аудио бичлэгийг хурлыг дахин сонсохыг хүссэн сонирхогч этгээдүүдэд зориулан хурал болсноос хойш хамгийн багадаа 30 хоног байрлуулна.

Аливаа телефон хурлын дараа Хорооны зүгээс товчхон хурал явуулж болно. Хэрэв ийм товч хурлаар өмнө нь нийтийн хүртээл болгоогүй дотоод мэдээллийн санамсаргүйгээр нийтийн хүртээл болгосон үйлдлийн талаар дурдаагүй бол, Ил тод байдлын хороо энэхүү Бодлогын дагуу авах шаардлагатай зохих арга хэмжээг тодорхойлно.

8.3 *Шинжээчдийн хурал*

Компанийн удирдлагууд хөрөнгө оруулагчид болон багцын менежерүүдтэй тухайн нөхцөл байдлаас хамаарч ганцаарчилсан, эсвэл бага бүлгээр үүлзалт хурал зохион байгуулахаас гадна шинжээчид болон хөрөнгө оруулагчдын хурлыг зохих цаг хугацаанд нь багтаан явуулна. Ерөнхийдөө, Гүйцэтгэх захирал эсвэл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч ийм хуралд оролцоно. Гүйцэтгэх захирал эсвэл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч ийм хуралд оролцох боломжгүй байвал, тухайн хурал болохоос өмнө, оролцож буй хүмүүст товч танилцуулга хийж, нийтийн хүртээл байдлыг хангахад туслах болно. Урьдчилан таамаглаж буй асуултуудад өгөх тайлбар, хариултуудыг урьдчилан бичиж, хэлэлцэх ёстой.

Шинжээчидтэй хийх яриаг нийтийн хүртээл болгосон дотоод мэдээлэл, бусад дотоод бус мэдээлэл болон нууцлалтай биш мэдээллүүдийн талаарх тайлбар, тодруулгаар хязгаарлах шаардлагатай.

Хэрэв ямар нэгэн шалтгааны улмаас аливаа хэлэлцүүлэг дээр нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээллийг шинжээчид, хөрөнгө оруулагчид болон хэвлэл мэдээллийнхэнд задрүүлсн бол, энэ талаар Ил тод байдлын хорооны гишүүдэд даруйхан мэдэгдэнэ. Түүний дараа энэхүү бодлогын дагуу Ил тод байдлын хорооноос ямар арга хэмжээг авахаа тодорхойлно.

8.4 *Шинжээчийн тайлан ба загварууд*

Шинжээчийн тайлангийн төсөл, санхүүгийн загвар, тэдгээрийн үндсэн таамаглалуудын талаар хэн ч тайлбар өгөхгүй байж болно. Степ нь бодит мэдээллийн үнэн зөв байдалд залруулга хийх, ерөнхийдөө мэдэгдэж буй эдийн засаг, салбарын чиг хандлагын талаар хэлэлцэж болно.

Шинжээчийн сүүлийн тайлан бол шинжээчийн пүүсийн өмч байх бөгөөд Степ тэдгээр тайлангуудыг олон нийтэд болон ажилчдад дахин түгээх, нийтийн хүртээл болгох замаар үнэн зөв болохыг нь батлахгүй. Зохих хуулиудын дагуу, Компанийн аливаа харилцаа болон компанийн стратегийн төлөвлөлт ба гүйцэтгэл тэдний шинжилгээнд хэрхэн нөлөөлсөн талаар хяналт тавихад нь туслах зорилгоор Степ шинжээчийн дүгнэлтүүдийг өөрийн ТУЗ, ахлах менежерүүд, зээлийн агентлагууд болон санхүүгийн ба мэргэжлийн зөвлөхүүдэд түгээж болно.

Степийн үйл ажиллагаанд шинжилгээ дүгнэлт хийсэн шинжээчдийн нэрсийн жагсаалт, компанийн нэр, утасны дугаар зэргийг өөрийн веб хуудсан дээрээ байрлуулна. Харин тэдгээр шинжээчдийн веб хуудас руу хөтлөх линк болон шинжээчийн тайлангийн хуулбаруудыг өөрийн веб хуудсан дээрээ байршуулахгүй.

8.5 *Шинжээчийн орлого, ашгийн ба бусад тооцоо*

Компанийн орлого, ашиг ба бусад тооцоотой холбогдуулан шинжээч нараас асуусан асуулт лавлагаанд Гүйцэтгэх захирлаас өгөх хариулт нь: хэдийн нийтийн хүртээл болсон компанийн таамаглал, удирдамж болон бусад шинжээчдийн гаргасан тооцооллын хүрээ ба дундажын талаарх мэдээллээр хязгаарлагдана. Ашгийн тооцоололтой холбогдуулан шинжээчдэд удирдамж өгөх бодлогыг Степ баримталдаггүй.

Хэрэв удирдлагаас ирээдүйн үр дүн нь Степээс өмнө нь гаргасан удирдамжийн хүрээнээс нэлээд их ноцтой давах магадлалтай байна хэмээн тодорхойлбол, Ил тод байдлын хороо өөрчлөлтийг тайлбарлахын тулд хэвлэлийн мэдэгдэл гаргах, телефон хурал явуулахын аль тохиромжтойг нь нэн даруйхан шийдвэрлэнэ.

8.6 *Салбарын хурал*

Степ Канадад болон өөр газарт төрөл бүрийн салбарын хурлуудад оролцож болно. Ерөнхийдөө, сонирхогч талуудтай хийх яриа хэлэлцээр нь нийтийн хүртээл болсон дотоод мэдээлэл, дотоод бус мэдээлэл болон нууцлалын бус мэдээллийн тайлбар, тодруулгуудаар хязгаарлагдана. Брошур болон бусад тараах материалуудыг нийтийн хүртээл болгохоос өмнө Гүйцэтгэх захирлаар, хэрэв шаардлагатай бол Ил тод байдлын хороогоор хянуулж батлуулах ёстой. Дотоод мэдээллийг нийтийн хүртээл болгох эсэхэд Гүйцэтгэх захирал хяналт тавина.

8.7 *Арилжааны бус үе ба Арилжааг түр зогсоох хугацаа*

Албан тушаалтнууд, тодорхой ажилчид, зөвлөхүүд болон бусад этгээдүүд тухайн улирлын болон жилийн эцсийн санхүүгийн таамагласан үр дүнгийн талаарх нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээллийг эзэмшиж байж болох учраас тухайн улирлын буюу санхүүгийн жилийн ("Арилжааны бус үе" гэх) санхүүгийн үр дүнг нийтийн хүртээл болгох өдрийн дараах Арилжааны нэг өдрийн (энд тодорхойлсоноор) эхлэх болон дуусах хугацаа нь нэлээд нууцлаг байдаг. "Арилжааны өдөр" гэдэг нь Торонтогийн Хөрөнгийн Бирж үнэт цаасны арилжаа хийхэд нээлтэй байх тэр өдрийг хэлнэ.

Нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээллээс шалтгаалан Компанийн зүгээс цаашид захирлууд, албан тушаалтнууд, сонгосон ажилчид, зөвлөхүүд болон бусад этгээдүүдийн нэмэлт арилжааг хориглосон хугацааг тогтоож болно. (“Арилжааг түр зогсоох хугацаа” гэх).

Арилжааны бус үе болон Арилжааг түр зогсоох хугацааны түршид бүх Хэвлэлийн төлөөлөгчидэд нийтийн хүртээл болгосон удирдамж, мэдээллээс иш татах, эсвэл тайлбарлахаас бусдаар санхүүгийн тайлангууд дээрхи тайлант үеийн орлогын тооцоо, санхүүгийн таамаглалтай холбогдуулан тайлбар хийхийг хориглодог. Иймэрхүү мэдээлэл харилцааг нийтийн хүртээл болсон, дотоод бус мэдээллээр хязгаарладаг. Арилжааны бус үе болон Арилжааг түр зогсоох хугацааны түршид бүх Хэвлэлийн төлөөлөгчид мөн хөрөнгө оруулалтын шинжээчид, үнэт цаас хувьцаа эзэмшигчид, ирээдүйн хөрөнгө оруулагчид болон хэвлэл мэдээллийнхэнтэй хөрөнгө оруулагчдад чухал байж болох аливаа зүйлсийн талаар үүлзалт, хурал зохион байгуулахаас зайлсхийх ёстой. Зөвхөн бодит баримттай мэдээлэлтэй холбоотой тодруулга асуултад хариу өгч болно. Гэхдээ Степ яг энэ хугацааны түршид шинжээчид болон хөрөнгө оруулагчидтай бүх харилцаагаа зогсоох хэрэгтэй. Жишээлбэл, бусад талуудаас зохион байгуулсан аливаа хөрөнгө оруулалтын үүлзалт, хуралд оролцох гэх мэт.

9. Хэвлэл мэдээллийнхэнтэй харилцах

Хэвлэл мэдээллийнхэнтэй харилцахдаа, дараах журмыг баримтална. Үүнд:

- (a) Степ аль нэг сэтгүүлчид онцгойлон аливаа нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээлэл болон холбогдох баримтуудыг өгөхгүй;
- (b) Хэвлэлийн төлөөлөгчид хэвлэл мэдээллийнхнээс ирсэн бүх асуултад хариулах ёстой. Илүү албан ёсны, бүрэн гүйцэт мэдээлэл өгөх үүднээс дээд шатны удирдлага эсвэл тухайн асуудлыг хариуцсан шинжээчээр гол асуудлууд дээр тайлбар өгүүлүүлж болно; мөн
- (c) Санхүүгийн асуудлаарх хэвлэлийн бага хурлыг хөрөнгө оруулагчидгүйгээр явуулдаг боловч нийтийн хүртээл болгосон мэдээлэлтэй бүгд танилцах боломжтой. Дотоод мэдээллийг ерөнхийд нь нийтийн хүртээл болгохгүй байдалд хяналт тавих үүднээс Гүйцэтгэх захирал ба/эсвэл Гүйцэтгэх дэд-ерөнхийлөгч хэвлэлийн бага хуралд оролцоно.

10. Нууц мэдээг задруулсан тохиолдол, цуу яриа, төөрөгдүүлсэн мэдээлэлтэй харьцах нь

Нууц мэдээг задруулсан тохиолдол, цуу яриа, төөрөгдүүлсэн мэдээлэлтэй харьцахдаа, дараах журмыг баримтална. Үүнд:

- (a) Торонтогийн Хөрөнгийн Биржээс тавигддаг аливаа шаардлагуудын дагуу Степ аливаа цуу ярианд, баталсан болон үгүйсгэсэн байдлаар, ямар ч тайлбар өгөхгүй байх бодлогыг баримтална. Интернэтээр тархсан цуу яриа ч үүнд мөн адил хамаарна. Торонтогийн Хөрөнгийн Биржээс тавигддаг аливаа шаардлагуудын дагуу Степээс томилогдсон Хэвлэлийн төлөөлөгч эдгээр цуу ярианд “Манай компани нийгэмд тархсан аливаа цуу ярианд тайлбар өгөхгүй байх бодлогыг баримталдаг” хэмээн хариулах шаардлагатай.;

- (b) Хэрэв Торонтогийн Хөрөнгийн Биржээс Степийг нийгэмд тархсан цуу ярианд хариулт өгөхийг зөвлөвөл, Гүйцэтгэх Захирал асуудлыг авч үзэж, хариултын мөн чанар, агуулгын талаар санал, мэдэгдэл бэлдэж Ил тод байдлын хороонд танилцуулна. Дараа нь Ил тод байдлын хороо Торонтогийн Хөрөнгийн Биржээс ирүүлсэн хүсэлттэй холбогдуулан, өөрийн бодлогоос гажих эсэхийг нь шийднэ; мөн
- (c) Хэрэв нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээлэлтэй холбогдсон цуу яриа бүхэлдээ, эсвэл тодорхой хэсэг нь үнэн зөв байвал, тухайн мэдээллийг нийтийн хүртээл болгох үүрэг үүснэ. Ийм нөхцөл байдалд, холбогдох дотоод мэдээллийг нийтийн хүртээл болгох, хэвлэлийн мэдэгдэл гаргахаа түр хойшлуулах, Компанийн үнэт цаасны арилжааг түр зогсоох эсэх талаар хэлэлцэхээр Компанийн зүгээс Торонтогийн Хөрөнгийн Биржтэй даруйхан холбоо барина.

11. Нийтийн хүртээл болгосон мэдээллийн бүртгэлийг хөтлөх

Компани дараах зүйлсийг бүртгэж, хадгална. Үүнд:

- (a) үнэт цаасны зохицуулагч байгууллагад бүртгэсэн бүхий л нийтийн хүртээл болгосон бичиг баримтуудыг таван-жил хадгална;
- (b) Ил тод байдлын хорооны бүх хурлын тэмдэгдэл, шийдвэрүүдийн хуулбарууд; ба
- (c) Аливаа танилцуулга, телефон хурал болон веб цацалтын тэмдэглэл, хэвлэлийнхэн, шинжээчидтай хийсэн хурлын протокол, тэмдэглэл ба Степд зориулан гаргасан шинжээчийн тайлангуудын хуулбарууд.

12. Цахим харилцаа холбоо

12.1 Ерөнхий

Энэ бодлогоор цахим харилцаа холбоонд хамаарах асуудлыг зохицуулна. Тиймээс, мэдээллийг амаар болон бичгээр нийтийн хүртээл болгох үүрэг хүлээсэн Төлөөлөгчид цахим харилцаа холбооны асуудлыг бодлогын дагуу шийдвэрлэнэ.

12.2 Веб хуудаснууд

- (a) Гүйцэтгэх захирал эсвэл Гүйцэтгэх захирлын томилсон этгээд Компанийн веб хуудас дээр гарсан бүх мэдээлэлийг үнэн зөв, бүрэн гүйцэт, хамгийн сүүлийн үеийн болон бүхий л холбогдох үнэт цаасны тухай хуулиуд, Торонтогийн Хөрөнгийн Биржийн дүрэм, журмууд болон энэ Бодлогын дагуу бэлдүүлж Компанийн веб хуудсанд хяналт тавина.
- (b) Компанийн веб хуудсанд чөлөөтэй хандах боломж нь нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээллийг ил болгосон гэсэн үг биш юм. Компанийн веб хуудас дээрх дотоод мэдээллүүдийг ямар нэгэн байдлаар нийтийн хүртээл болгохоос өмнө хэвлэлийн мэдэгдэл гаргана;

- (c) Хэрэв Степ өөрийн үнэт цаасыг хуваарилах талаар бодож байгаа бол, холбогдох үнэт цаасны тухай хуулинд нийцүүлж үнэт цаасыг арилжихын өмнө болон арилжих үеэр Компанийн веб хуудасны агуулгыг хянан шалгах ёстой;
- (d) хөрөнгө оруулагчтай харилцах харилцаатай холбоотой бүхий л материалыг Компанийн веб хуудас дээр тусдаа хэсэгт байршуулах бөгөөд уг материалд нийтлэсэн мэдээлэл мэдээллийг нийтлэх үеийн байдлаар үнэн зөв мэдээлэл байсан болохыг уншигчид сануулсан мэдэгдлийг мөн багтаана. Компанийн веб хуудас дээр нийтлэгдсэн бүх материалд тухайн материалыг бэлдсэн он сар өдрийг оруулна. Компанийн веб хуудас дээр нийтлэгдсэн материалд өөрчлөлт оруулах бол нэн даруйхан шинэчилж оруулна.;
- (e) Компанийн веб хуудасны Хөрөнгө оруулагчийн харилцааны хэсэгт дараах мэдээлүүдийг оруулна. Үүнд:
- (i) Канадын үнэт цаасны хадгаламжийн төвийн үйлчилгээ болох Цахим баримт бичгийн дүн шинжилгээ, хайлтын систем (SEDAR)-д Канадын үнэт цаасны зохицуулагч байгууллагад бүртгүүлсэн бүхий л бичиг баримтуудын бүрэн гүйцэт хуулбарууд зэрэг нийтийн хүртээл болсон бүхий л мэдээлэл; ба
 - (ii) баримтат хуудас, илтгэл, хөрөнгө оруулагчийн танилцуулга болон шинжээчийн ба салбарын хурлууд дээр танилцуулсан материалууд зэрэг шинжээчид, хөрөнгө оруулагч байгууллагууд болон бусад зах зээлийн мэргэжилтнүүдэд өгсөн бүхий л мэдээлэл;
- (f) Компанийн веб хуудаснаас аливаа гуравдагч этгээдийн веб хуудас руу шилжих линкүүд дээр дарахад таныг Компанийн веб хуудаснаас гарч байгаа ба өөр сайтууд дээр гарсан мэдээллийн үнэн зөвийг Степ хариуцахгүй гэсэн агуулга бүхий мэдээ гарч ирнэ;
- (g) Компанийн бизнес, үйл ажиллагаатай хамаатай ямар ч нийтлэлийг Компанийн веб хуудсан дээр нийтлэхгүй; ба
- (h) Гүйцэтгэх захирал ба/эсвэл итгэмжлэгдсэн этгээд нь дараах үүргийг хүлээнэ:
- (i) аливаа мэдээллийг нийтийн хүртээл болгосны дараа уг мэдээллийг Компанийн веб хуудсанд нийтлэх;
 - (ii) Компанийн веб хуудас дахь мэдээлэл үнэн зөв, бүрэн гүйцэт, хамгийн сүүлийн үеийн болон Энэхүү Бодлого, Торонтогийн Хөрөнгийн Биржийн дүрэм журам ба бусад ил тодтой холбоотой шаардлагуудын дагуу бэлдэж нийтэлсэн болохыг баталгаажуулах үүднээс тогтмол хянаж, хуучирсан болон ташаа мэдээллийг тогтмол шинэчилж, нийтийн хүртээл болгох;
 - (iii) хуучирсан болон ташаа мэдээллийг цаг тухайд нь устгаж, архивлагдсан мэдээлэл рүү нэвтрэх линк буюу холбоос руу автоматаар шилжүүлэх;
 - (iv) Компанийн веб хуудас дээрх дараах ангиллын мэдээлүүдийг дор дурдсан хугацаагаар хадгална:

- (a) жилийн эцсийн санхүүгийн тайланг таван жилээр;
 - (b) улирлын санхүүгийн тайланг гурван жилээр;
 - (c) хэвлэлийн мэдэгдэл болон бусад арилжааны мэдэгдлийг гурван жилээр;
 - (d) жилийн эцсийн мэдээллийн маягыг хоёр жилээр;
 - (e) Үндэсний гэрээ 43-101 техникийн тайлангуудыг нэг жилээр;
 - (f) хөрөнгө оруулагчийн тайланг 6 сараар;
 - (g) веб цацалт ба хөрөнгө оруулагчийн хурлын тэмдэглэлийг нэг сараар;
- (v) веб хуудас дээр нийтэлсэн ба/эсвэл веб хуудаснаас устгасан бүхий л дотоод мэдээллийн огноо ба агуулга зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан бүртгэлийг хөтлөх;
 - (vi) Компанийн веб хуудаснаас гурвагч этгээдийн веб хуудас руу нэвтэрч орохыг зөвшөөрөх, болон иймэрхүү бүх холбоос линк дээр дарахад үншигчид өөрийг нь Компанийн веб хуудаснаас гарч байгаа ба өөр веб хуудасны агуулгыг Степ хариуцахгүй болохыг сануулдаг болгох; ба
 - (vii) цахимаар ирсэн бүхий л асуултуудад хариулт өгөх, ингэхдээ зөвхөн энэхүү Бодлогын дагуу нийтийн хүртээл болгож болох мэдээллийг уг хариултандаа ашиглана.

12.3 Интернетийн чат рүм буюу хөөрөлдөх өрөө ба Цахим мэдээллийн самбар

Нийтийн хүртээл болоогүй ямар ч дотоод мэдээллийг санамсар болгоомжгүйгээр нийтийн хүртээл болгохгүйн тулд Гүйцэтгэх захирал эсвэл Ил тод байдлын Хорооноос зөвшөөрөл өгөөгүй л бол Компанийн бизнес, үйл ажиллагаа ба үнэт цаастай холбоотой аливаа асуудлаар Компанийн ямар ч Төлөөлөгч ямар ч чат буюу хөөрөлдөх өрөө, бүлгийн хэлэлцүүлэг эсвэл цахим мэдээллийн самбарт орохгүй.

12.4 Цахим шуудан

Компанийн бүхий л цахим шуудангийн хаяг нь Компанийн компанийн өмч бөгөөд, ийм цахим шуудангаар илгээсэн, эсвэл хүлээн авсан бүхий л харилцааг компанийн харилцаа гэж үзэх бөгөөд энэхүү Бодлогын дагуу зохицуулна.

13. Ирээдүйн таамаглал мэдээлэл

Хэрэв Степ ирээдүйн таамаглал мэдээллийг бичиг баримтаар, танилцуулгаар эсвэл олон нийтийн бусад хэрэгслээр нийтийн хүртээл болгохоор шийдвэл, эсвэл нийтийн хүртээл болгох шаардлага гарвал, дараах бүхий л эрх зүйн шаардлагуудыг даган мөрдөнө. Үүнд:

- (a) Ирээдүйн таамаглал мэдээллийг зөвхөн Гүйцэтгэх захирлын тодорхойлсон нөхцөл байдалд л гаргана;
- (b) Холбогдох үнэт цаасны тухай хууль болон Торонтогийн хөрөнгийн биржийн дүрэм, журмын дагуу шаардагдах ил тодын баримт бичигт аливаа ирээдүйн таамаглал мэдээллийг өгөхөөр болбол, уг мэдээллийг ирээдүйн таамаглал мэдээлэл гэж тэмдэглээд, ирээдүйн таамаглал мэдээллийг бэлтгэхэд ашигласан бүхий л чухал таамаглалуудыг үндэслэлтэйгээр, дэлгэрэнгүй тайлбарлана;
- (c) бүхий л ирээдүйн таамаглал мэдээллийг холбогдох үнэт цаасны тухай хууль, тогтоомж ба Торонтогийн Хөрөнгийн Биржийн дүрэм журмын дагуу нийтийн хүртээл болгож, шинэчилж, эргүүлэн татна;
- (d) бичгээр болон амаар гаргасан аливаа мэдэгдэлийг зохих урьдчилан тооцоолоогүй нөхцлийн талаар анхааруулсан санамж дагалдана. Уг санамж нь бодит үр дүн уг мэдэгдэлд дурдсан нөхцөл байдлаас өөр үр дүнг авчирч болох болзошгүй эрсдэл, тодорхойгүй нөхцөл байдлыг тодорхойлно;
- (e) бүхий л ирээдүйн таамаглал мэдээллийг Степ шинэ мэдээлэл, ирээдүйн үйл явдлын үр дүн зэрэг ирээдүйн таамаглал мэдээллийг шинэчлэх эсвэл засварлах үүрэггүй болох тухай мэдэгдэл дагалдана. Энэхүү үгүйсгэсэн мэдэгдлийг үл харгалзан, хэрэв дараа нь болох үйл явдал өмнөх мэдэгдлээс өөр байх болно гэдгийг бодитоор нотолбол, холбогдох үнэт цаасны тухай хууль, Торонтогийн Хөрөнгийн Биржийн дүрэм журмын аливаа шаардлагын дагуу Степ өөрийн үзэмжээр, ирээдүйн таамаглал мэдээллийг шинэчлэх, эсвэл засварлах эсэхээ шийднэ;
- (f) аливаа телефон хурал, илтгэлийн эхэнд Хэвлэлийн төлөөлөгч ирээдүйн таамаглал мэдээллийн талаар хэлэлцэх тухай мэдэгдэл гаргана. Энэ мэдэгдэл нь таамаглал болон гарч болзошгүй эрсдэл, тодорхойгүй нөхцөл байдлын талаарх нийтийн хүртээл болсон бичиг баримтад агуулагдсан анхааруулга, санамжийг багтаана; мөн
- (g) хэрэв Степ холбогдох үнэт цаасны тухай хуулинд нийцүүлэн санал болгосон баримт бичигтэй холбогдуулан таамаглал, төсөл төлөвлөгөө гаргасан бол, Степ холбогдох үнэт цаасны тухай хууль, Торонтогийн Хөрөнгийн Биржийн дүрэм журмын дагуу тухайн таамаглал, төсөл төлөвлөгөөг шинэчлэнэ.

14. Энэхүү Дүрмийг зөрчсөнөөс үүдэн гарах үр дагавар

Энэхүү Бодлогыг дагаж мөрдөхгүй байх нь дотоод сахилга батын арга хэмжээ авах, урьдчилан мэдэгдэлгүйгээр хөдөлмөр эрхлэлтийг зогсоох хүртэл томоохон үр дагаварт хүргэж болзошгүй юм. Энэ Бодлогыг зөрчих нь Торонтогийн Хөрөнгийн Биржийн дүрэм, журам гэх мэт Канадын үнэт цаасны тухай хуулийг зөрчсөн үйлдэл болох бөгөөд хэрэв аль нэг захирал, албан тушаалтан, ажилтан тухайн хууль, журмыг зөрчсөн байж болзошгүй гэж үзвэл Степ уг асуудлыг холбогдох байгууллагад хүргүүлнэ Ингэснээр торгууль, шийтгэвэр оноох, бүр цаашилбал хорих ялаар шийтгүүлж болно.

15. Даган мөрдөх тухай баталгаа

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс тогтоосон бүх Төлөөлөгчид Компанийн Бизнесийн ёс зүйн дүрэмд хавсаргасан маягтаар энэхүү Бодлогыг даган мөрдөх тухай баталгааг гарган өгнө.

Компанийн Гүйцэтгэх захирал компанийн бүх захирлууд, ажилтнууд, нэр заасан зөвлөхүүд болон гүйцэтгэгч нараас жил бүрийн санхүүгийн хамгийн эхний улирлын эцэст эсвэл түүнээс өмнө Даган мөрдөх тухай баталгааг хүлээн авч, тэдгээр баталгаануудыг хүлээн авсан тухай баталгаажуулах мэдэгдлийг бичгээр гарган, үр дүнг нь нэгтгэж Зөвлөлд хүлээлгэн өгөх ажлыг хариуцна.

16. Дүрмийн хэрэгжилтийг үнэлэх нь

Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Компанийн нийтийн хүртээл болгох үүргийн уг Бодлого нь мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөв, бүрэн гүйцэт нийтийн хүртээл болгоход үр дүнтэй байгаа эсэхийг тогтоох зорилгоор жил бүр энэхүү Бодлогын хэрэгжилтийг хянан, үнэлнэ.

17. Лавлах зүйлс

Энэхүү Бодлогыг хэрхэн мөрдөх талаар асууж тодруулах зүйл байвал, Компанийн Гүйцэтгэх Захиралтай холбогдоно уу.

Хамгийн сүүлд батласан огноо:: 2017 оны 10 сарын 2

Баталсан: Компанийн засаглал ба Нэр дэвшүүлэх хороо
Төлөөлөн Удирдах Зөвлөл